



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/191

Улаанбаатар хот

“Иж бүрэн шалгалт зохион байгуулах тухай”

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 124 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах нийтлэг журам”, Онцгой байдлын ерөнхий газар, түүний харьяа салбар нэгжүүд, Онцгой байдлын газар, хэлтэс, Улсын нөөцийн анги салбаруудад 2018 онд иж бүрэн болон биелэлтийн шалгалтад хамрагдах нэгдсэн хуваарийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд иж бүрэн шалгалтыг 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

2. “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Иж бүрэн шалгалт зохион байгуулах удирдамж”-ийг хоёрдугаар, “Зардлын тооцоо”-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Зүүн бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газар (хурандаа Н.Гантөмөр), Хэнтий аймгийн Онцгой байдлын газар (хурандаа Д.Батжаргал), Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар (хурандаа Т.Энхбаатар)-т үүрэг болгосугай.

4. Шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж, дүнг 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (хурандаа Б.Батболд)-д үүрэг болгосугай.

5. Ажлын хэсгийн томилолтод шаардагдах 812 000 /найман зуун арван хоёр мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газар (хошууч Я.Гантөмөр), жолоочийн томилолт, автомашин, шатах тослох материалд шаардагдах 1 101 515 /нэг сая нэг зуун нэг мянга таван зуун

арван тав/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Хангалт үйлчилгээний анги
(хурандаа С.Бямбасүрэн)-д тус тус зөвшөөрсүгэй.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ